БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУРИМТЛАГДАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААРХ


БОАЖЯ-ны Байгаль орчны үнэлгээ,
аудитын хэлтэс

БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ БҮТЭЦ



Байгаль орчны стратегийн үнэлгээ



Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ



Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ



Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Үнэлгээ

LOPMENT

Стратегийн үнэлгээ

УИХ, ЗГ-аас батлагдах бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөөнд хийнэ

Төлөв байдлын үнэлгээ

Томоохон бүх төслүүдэд төслийн баримт бичгийг боловсруулах шатанд хийнэ.

Нөлөөллийн үнэлгээ

Шинээр байгуулж байгаа болон одоо ажиллаж буй үйлдвэрлэл, үйлчилгээ, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх, байгалийн нөөц ашиглах аливаа төсөлд хийнэ.

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ

Тодорхой бүс нутаг, усны сав газрын хэмжээнд /иргэн, аанб-аас хэрэгжүүлж буй төслүүдэд/ хийнэ.

Ерөнхий үнэлгээ

Хэрэгжүүлэх боломжгүй

Нөхцөл болзолтой хэрэгжүүлэх

Нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай

Нарийвчилсан үнэлгээ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

6 дугаар зүйл.Төлөв байдлын болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ

6.1.Төсөл хэрэгжүүлэгч нь энэ хуулийн 3.1.4-т заасан үнэлгээг хийлгэж, болзошгүй нөлөөллийг судалсан байна.

6.2.Төлөв байдлын үнэлгээг төсөл хэрэгжүүлэгч нь эрх бүхий мэргэжлийн байгууллага болон судалгаа, шинжилгээний байгууллагын оролцоотойгоор хийлгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандан чиглэл гаргуулна.

6.3.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тодорхой бүс нутаг, сав газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөлд энэ хуулийн 3.1.5-д заасан үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хийнэ.

6.4.Шаардлагатай тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 6.3-т заасан үнэлгээ хийхэд мэргэжлийн баг томилж болно.

6.5.Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ажилд шаардагдах зардлыг нөлөөллийн цар хүрээг харгалзан төсөл хэрэгжүүлэгчээс гаргуулна.

6.6.Эрх бүхий мэргэжлийн байгууллага нь боловсруулсан байгаль орчны төлөв байдлын үнэлгээ болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх үнэлгээний асуудал эрхэлсэн мэргэжлийн зөвлөлд хүргүүлж хянуулна.

3.1.4.“байгаль орчны төлөв байдлын үнэлгээ” гэж аливаа төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлохыг;

3.1.5.“хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ” гэж тодорхой бүс нутаг, сав газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслүүдээс хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа хам болон давхардмал сөрөг нөлөөллийг тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг;

Хуримтлагдах үнэлгээний зохицуулалт ба үндсэн ойлголт:

- Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор Байгаль орчны Стратегийн болон Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журамаар зохицуулагдана.
- Аргачлал батлах тухай Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-117 дугаар тушаалаар батлагдсан Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал,
- Журам батлах тухай” Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын сайдын 2014 оны А-03 дугаар тушаалаар батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам зэрэг болно.

3. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх

3.1. Тодорхой бүс нутгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа хэд хэдэн төслийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 6.3-т заасны дагуу мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хийнэ.

3.2. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь үнэлгээ хийх мэргэжлийн байгууллагыг тухай бүр нээлттэй шалгаруулалтаар сонгоно.

3.3. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх ажлын даалгаврыг байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

3.4. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх мэргэжлийн байгууллага нь батлагдсан ажлын даалгаврын дагуу үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж бүхий тайлан гаргах ба тайлан нь дараах мэдээллийг агуулна:

3.4.1. тухайн бүс нутгийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт;

3.4.2. тухайн бүс нутгийн байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлсэн болон үзүүлж байгаа гол сөрөг нөлөөллүүд, тэдгээрийн үр дагаврын тодорхойлолт;

3.4.3. хуримтлагдах нөлөөллийн эрчим, цар хүрээ (цаг хугацаа, орон зай), тархалт;

3.4.4. хуримтлагдах нөлөөллийн эх үүсвэрүүд, түүнийг хариуцах этгээд, тэдгээрийн нөлөөлөлд эзлэх хувь хэмжээ;

3.4.5. сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, зардлын тойм, тэдгээрийн хувилбарууд;

3.4.6. хуримтлагдсан сөрөг нөлөөллөөс үүдэн бий болсон байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндийн хохирлын үнэлгээ;

3.4.7. цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хяналт тавих шалгуур үзүүлэлтүүд;

3.4.8. нөлөөлөлд өртсөн бүс нутаг дахь олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүн;

3.4.9. дүгнэлт, зөвлөмж.

3.5. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайланг үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага нь байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.6. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайлангийн хураангуй болон дүгнэлт (зөвлөмж)-ийг ажлын 14 хоногийн хугацаанд өөрийн байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтийн саналыг авна.

3.7. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайланг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 4.2-т заасан мэргэжлийн зөвлөл хэлэлцэн дүгнэлт гаргаж, тухайн бүс нутагт цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийн хамт байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад танилцуулна.

3.8. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийхэд шаардагдах зардлыг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 6.5-т заасны дагуу төсөл хэрэгжүүлэгч хариуцна.

3.9. Шаардлагатай тохиолдолд үнэлгээний ажилд шаардагдах зардлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага урьдчилан гаргаж болох бөгөөд уг зардлыг үнэлгээний дүгнэлтэд үндэслэн хуримтлагдсан нөлөөллийн цар хүрээ, эзлэх хувь хэмжээг харгалзан төсөл хэрэгжүүлэгчээс гаргуулна.

3.10. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээтэй холбоотой гарсан маргааныг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР




Байгаль орчны стратегийн үнэлгээ

/ Уул уурхайн бүс нутагт /



Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ

/Заамар, Дорноговь аймаг, Таван толгой Баганууурын уурхай /



Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ



Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн сэргээлтийн зардал

Байгаль орчны хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг хийхэд тулгамдаж буй асуудал

- Байгаль орчны хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг хийх, санхүүжүүлэх, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дараах хүндрэл гарч байна. Үүнд:Улсын төсвийн хүдрэлээс болж дараагийн хийгдэх Өвөрхангай аймгийн Уянга, Архангай аймгийн Цэнхэр сумын алтны бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ, уулын баяжуулах Эрдэнэтийн зэс молибдены бүс нутагийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ зэрэг ажлууд одоогоор улсын төсвийн хөрөнгөөр /хөрөнгө оруулалтын зардал, байгаль хамгаалах сан/, хийгдэх боломжгүй болоод байна.
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 6 дугаар зүйл, Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журмын 3 дугаар зүйлд хийгдсэн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлэх, төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хүлээх үүргийг тодорхой тусгаж өгөөгүй байна.
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 6.5-д байгаль орчны хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх зардлыг төсөл хэрэгжүүлэгч гаргахаар заасан байна. Одоогоор хийгдсэн 4 хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний зардлыг улсын төсөв болон яаманд хэрэгжиж буй төслөөс санхүүжүүлэн хийв. Дээрх хуулийн заалт нь аж ахуйн нэгж буюу төсөл хэрэгжүүлэгчид санхүүгийн хувьд дарамт учруулдаг.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

- Байгаль орчны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд хуримтлагдах нөлөөллийн үнэлгэний зөвлөмж дүгнэлтийг хэрэгжилтийг хангахад хөшүүрэг болохуйц зүйл, хэсэг, заалтыг оруулах,
- Дээрх хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулах төслийн хүрээнд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний холбогдох дүрэм журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулах
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам дээр хэрэгжиж байгаа төслүүд болох Дэлхийн банкны Уул уурхай, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл, Канадын Засгийн газрын Монгол Улсад олборлох салбарын удирдлагыг бэхжүүлэх төсөл, Канад улсын Засгийн газрын MERIT төсөл зэрэг төслүүдээр санхүүжүүлэн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх,


ХУРИМТЛАГДАХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ
БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ
МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ /Үнэлгээ, аудит/
СТРАТЕГИЙН ҮНЭЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ
Хянан магадлагааны үр дүнг

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА